



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/93

Өмнөдэлгэр сум

**Цэрэг татлага зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, Батлан хамгаалахын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12, 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2026 оны А/147 дүгээр захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2026 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр явуулсугай.
2. Цэрэг татлага зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Баярмаа

Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Х.Саруултуяа

ХААТасгийн дарга

Гишүүд: Д.Наранчимэг

1-р багийн Засаг дарга

Г.Эрдэнэсүвд

2-р багийн Засаг дарга

А.Баянмөнх

3-р багийн Засаг дарга

М.Сод-Ирээдүй

4-р багийн Засаг дарга

Э.Заяабаяр

5-р багийн Засаг дарга

С.Шижирбаатар

6-р багийн Засаг дарга

Ц.Ариунтунгалаг

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Т.Мөнхтөр

Соёлын төвийн даргын үүргийг түр  
орлон гүйцэтгэгч

Т.Эрдэнэтуяа

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

3. Зарлан дуудах мэдэгдлийг нэрсийн жагсаалтад орсон цэргийн албанд татагдагч бүрд хүргүүлэн, заасан хугацаанд Цэрэг татлагын байранд бэлэн байлгах, тэдний бичиг баримтыг бүрдүүлэх, цэргийн албанд татагдагчдыг үдэж мордуулах, цэргийн албанаас халагдан ирж буй дайчдыг угтан авч, тэднийг ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Цэрэг татлагын байрыг зааврын дагуу бэлтгэж, Цэрэг татлагын товчоо, зохион байгуулах бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийг Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Мөнхтөр), Хөдөө аж ахуйн тасгийн дарга (Х.Саруултуяа) нарт даалгасугай.
5. Цэрэг татлагад шаардагдах зардлыг Засаг даргын нөөц сангаас шийдвэрлэхийг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.
6. Цэрэг татлагын ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Баярмаа)-д даалгасугай.



Т.МӨНХТӨР